



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/200

Хэрлэн сум

**Сэргээгдэх эрчим хүчний төсөл  
боловсруулахад хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хоёрдугаар хуралдааны “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 05 дугаар тогтоол, 2023 оны хорин гуравдугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.5.8 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа хийж төсөл боловсруулах зардалд Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн Хэнтий аймгийн салбарт 2,000,000 (хоёр сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ